



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 13 өдөр

Дугаар А/655

Булган сум

Нэгж талбар нэгтгэх тухай

Монгол Улын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын харилцаа, барилга, геодези зураг зүйн газрын даргын 2010 оны 16 дугаар тушаалаар баталсан “Нэгж талбар дугаарлах журам”-ын 5.3 дахь заалт, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар баталсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Нүнжигт өргөө” ХХК (3191958)-ын Булган сум 5 дугаар баг Д.Дамбын 2 дугаар гудамж 208а тоотод байршилтай 6308009465 нэгж талбарын дугаартай нийтийн орон сууц зориулалтаар эзэмшиж буй 654 м² газрыг 208б тоотод байршилтай 6308009561 нэгж талбарын дугаартай 114 м² нийтийн орон сууц зориулалтаар эзэмшиж буй нэгж талбаруудыг нэгтгэж 768 м² талбайгаар гэрээ байгуулж, гэрчилгээжүүлэхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т зөвшөөрсүгэй.

2. Газрыг зориулалтын дагуу зүй зохистой эзэмшихийг иргэн “Нүнжигт өргөө” ХХК (Л.Мөнхтөр)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны А/633 дугаар захирамжийн “Нүнжигт өргөө” ХХК-тай холбогдох хэсэг, 2023 оны А/546 дугаар захирамжийг тус тус хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ